



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 07 өдөр

Дугаар 112

Номгон

**“Цахим архив-Баянхонгор” дэд
хөтөлбөрийн хэрэгжүүлэх хугацааг
сунгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн болон байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг мэдээллийн технологит шилжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хугацааг 2020-2024 онд хэрэгжүүлэхээр сунгасугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүр төсөвлөн, орон нутгийн төсөвт тусгаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

1190297